



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Д.ГАНМАА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Засгийн газрын VIII байр, Олимпын гудамж 2,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (976-51) 26 36 95, Факс: (976-11) 32 35 41
Цахим шуудан: letter@moh.gov.mn
Цахим хуудас: www.moh.gov.mn

2026.06.25 № 01/3117
танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Таны 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 32 дугаар албан бичгээр ирүүлсэн эрүүл мэндийн байгууллагуудын сонгон шалгаруулалтын талаар асуулттай танилцаж, хариуг хүргүүлж байна.

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны "Журам шинэчлэн батлах тухай" 02 дугаар тогтоолын дагуу лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн сонгон шалгаруулалтыг 2022 онд зохион байгуулж, гэрээ байгуулсан. Гэрээний хугацаа 3 жил үргэлжилж, 2025 оны 9 дүгээр сард дууссан.

Нэгдсэн сонгон шалгаруулалтыг 2025 оны 8 дугаар сард зохион байгуулах байсан боловч эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт нийцүүлэн тусламж, үйлчилгээг худалдан авах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээнд үндэслэн эмнэлгийн орны тоо, хүний нөөцийн төлөвлөлт, бүтэц үйл ажиллагааны стандарт, эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалтад хяналт шинжилгээ хийх, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлэг, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, зарчим, санхүүжүүлэх журмын шинэчлэлт зэрэг бэлтгэл хангах шаардлагаас шалтгаалан хойшилсон болно.

2. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудын дунд нэгдсэн сонгон шалгаруулалтыг 2022 оны 3 дугаар сараас 8 дугаар сарын 15-ны өдрийн хооронд өмчийн хэлбэр заахгүйгээр зохион байгуулсан. Тус сонгон шалгаруулалтад 345 эрүүл мэндийн байгууллага материал ирүүлснээс нэгдүгээр шатанд 335 байгууллага тэнцсэн. Сонгон шалгаруулалтын хоёрдугаар шатанд нийт 325 эрүүл мэндийн байгууллага тэнцсэн.

Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэгдсэн болон тусгай зөвшөөрлийн мэдээлэл ирүүлээгүй, хүчинтэй хугацаа дууссан, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй байх, шүүхийн шийдвэрээр албадан хэрэгжүүлэх арга хэмжээ байхгүй талаар тодорхойлолт ирүүлээгүй, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй, шүүхээр албадан хэрэгжүүлэх арга хэмжээтэй, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/48 дугаар тушаалаар баталсан "Лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулахад тавигдах тусгай шаардлага"-ыг хангаагүй, сонгон шалгаруулалтын хоёрдугаар шатанд материал ирүүлээгүй шалтгаанаар сонгон шалгаруулалтад 20 байгууллага тэнцээгүй бөгөөд тэнцсэн 325 байгууллагаас 85 байгууллага нь төрийн өмчит, 240 байгууллага нь хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байсан.

3. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.11 "эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах" гэж заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн "Журам шинэчлэн батлах тухай" тогтоолын төслийг боловсруулан, яамдуудад хүргүүлсэн бөгөөд Сангийн яамны 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 01/7694 дүгээр албан бичиг, Эрүүл мэндийн яамны 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 1/3024 дугаар албан бичгээр тогтоолын төсөлд тусгах саналыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар тогтоолын төсөл хэлэлцэгдэн батлагдаж, Захиргааны ерөнхий хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт заасны дагуу захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсний дараа нэгдсэн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Хүндэтгэсэн,